ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ · 2025 оны 4-р сарын 4

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗАРИМ НЭР ТОМЬЁОНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Хууль зүй дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлэгт Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Өнөрмаагийн хэлэлцүүлсэн "Эрүүгийн хууль дахь зарим нэр томьёонд хийсэн дүн шинжилгээ" сэдэвт илтгэлийг хүргэж байна.

Хууль дээдлэх зарчмын баталгааны нэг хэсэг нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх орчин, хариуцлага гарцаагүй байх, хууль тодорхой ойлгомжтой байх, хууль тогтвортой байх зэрэг олон хүчин зүйлийг нэрлэж болно.

Тэгвэл хууль тогтвортой нэг мөр хэрэгжих боломж ямар байгааг тухайлбал Эрүүгийн хуулийн тухайд авч үзье.

2002 оны Эрүүгийн хуульд 2004-2015 он хүртэлх хугацаанд нийт 13 удаа 2015 оны Эрүүгийн хуульд 2016-2023 он хүртэлх хугацаанд нийт 9 удаа нэмэлт өөрчлөлт орсноос хамгийн их нь 2017 онд 194 зүйл хэсэг, 2021 онд 14 зүйл хэсэг, 2022 онд 17 зүйл хэсэг, 2024 онд 4 зүйл хэсэгт нэмэлт өөрчлөлт орж, үүнийг дагаж холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оржээ.

Нэмэлт өөрчлөлт оруулсан гол агуулга нь ялын бодлогыг чангатгах, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа болон зарим төрлийн гэмт хэргийг шинээр нэмэх зэрэг зохицуулалтыг оруулсан байна.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь хуулийн зарим заалт эрүүгийн эрх зүйн нийтлэг жишиг, суурь зарчимтай илт зөрчилдсөнөөс гадна хүний эрх, нийгмийн шударга ёсны хэм хэмжээ, агуулгыг алдагдуулах ноцтой үр дагаварт хүргэхээр байгаа тохиолдолд зүй ёсны бөгөөд энэ байдал нь судалгаанд үндэслэгдсэн байх ёстой.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч нэр томъёоны хувьд дахин боловсронгуй болгох шаардлага байгааг доорхи үндэслэлээр харуулахыг зорилоо.

<u>Нэг. Эрүүгийн хууль дах хүч оруулсан, хоёрдмол утга бүхий үг, холбоосын талаар</u>

Хууль бол эрх зүйн хэм хэмжээний акт бөгөөд бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөөс батлан гаргасан дээд хүчин чадал бүхий баримт бичиг байдаг. Тиймээс ч хуулийн заалт бүх хүнд ойлгомжтой, тодорхой байх зарчимтай. Тухайлбал ХБНГУ-ын Холбооны яамны үйл ажиллагааны нийтлэг журмын 42 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт зааснаар *“Хууль хэлзүйн хувьд зөв, аль болох бүх хүнд ойлгогдохоор байх ёстой бөгөөд эрх зүйн хэм хэмжээг тодорхойлохдоо тухайн зохицуулах гэж буй харилцаанд хэрэглэгдэх хэм хэмжээ хэл зүйн хувьд яг тохирсон байхыг шаарддаг. Мөн хуулийн төслүүдийг хуулийн хэлний редакцид шилжүүлж, хэл шинжлэлийн хувьд зөв, ойлгомжтой эсэхийг шалгуулсан байх ёстой*” гэж зохицуулсан байна.[1]

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 36.4 дүгээр хэсэгт ***“тогтоолын.....шийдвэрлэх асуудлыг энгийн, ойлгомжтой байдлаар томъёолж бичнэ***”, мөн хуулийн 30 дугаар зүйл буюу Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих шаардлага хэсгийн 30.1.3 дахь хэсэгт “***үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих***” гэсэн шаардлага тавьжээ.

Эрх зүйн хэм хэмжээний нөхцөл, үндэслэл, заалт, журмууд нь хоорондоо логик зүй тогтлоор холбогдон тэнцвэржиж, хийдэлгүй зөрчилгүй уялдан хуульчлагдсан байх ёстой[2] бөгөөд хуулинд байгаа үг, холбоос таслал аливаа үйл явдалд дүгнэлт өгөхөд цаашлаад хүний хувь заяаг шийдвэрлэхэд асар их нөлөөтэй байдаг.

Хууль боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах бүхий л үе шатанд хууль зүйн техник буюу эрх зүйн хэм хэмжээний актын төсөл боловсруулах, батлан гаргах, нэгэнт батлагдсан актыг системчлэхэд ашиглаж байгаа тусгай арга хэрэгслийг анхааралагүйгээс сул, олон утга илэрхийлж болох үг хэллэг оруулснаас хуулийг хэрэгжүүлэхэд гажуудал үүсгэх эрсдэлтэй.

Хуулийг “хэл зүй, үг зүйн” талаас тайлбарлахын тулд хэлзүйн шинжлэх ухааны олон судлагдахууныг танин мэдэх, судлах, зөв ойлгох шаардлагатай юм.

Холбоос үгийг 2002, 2015 оны Эрүүгийн хуульд хичнээн удаа хэрэглэснийг дараахь хүснэгтээс харж болно:[3]

2002		2015	
Холбоос үг	**Нийт**	**Холбоос үг**	**Нийт**
ба	4	ба	16
буюу	316	буюу	1
болон	223	болон	30
эсхүл	378	эсхүл	683
түүнчлэн	79	түүнчлэн	1

2002		2015	
Холбоос үг	**Нийт**	**Холбоос үг**	**Нийт**
ба	4	ба	16
буюу	316	буюу	1
болон	223	болон	30
эсхүл	378	эсхүл	683
түүнчлэн	79	түүнчлэн	1

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж түүхэн хөгжлийн хувьд эрүүгийн хууль төрөлжүүлэгдэх тусам түүнд хэрэглэсэн нэр томъёо нь улам боловсронгуй болж, үгэнд хэмнэлттэй байх сул, холбоос үг бага хэрэглэх зарчмыг баримталж буй нь харагдаж байгаа боловч хүч оруулсан үг хэрэглэх нь хэвээр байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх хэсэгт **“хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх”** шаардлага зөрчигдөж буй жишээ:

1.1 Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.8 дугаар зүйлд заасан “Хүүхэдтэй хэрцгий харьцах” гэмт хэргийн үндсэн шинжид “хэрцгий” гэж тусгайлан хуульд тусгасан тул энэхүү үгний утга, агуулга, хэрэглээг судлан үзлээ.

Эрүүгийн хуульд хэрцгий гэх үг 8 удаа бичигджээ.

- Эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, **хэрцгий**, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна /зарчим/

- бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж **онц харгис хэрцгий аргаар**, тохуурхан доромжилж үйлдсэн /эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл/

- **онц харгис хэрцгийгээр** /хүнийг алах/

- **харгис хэрцгий** аргаар /хүчиндэх/

- **харгис хэрцгий** харьцсан, догшин авирласан, тарчлаасан /гэр бүлийн хүчирхийлэл/

- Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа **хэрцгий** харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэсэн /хүүхэдтэй хэрцгий харьцах/

- Дайны олзлогдогч, эсхүл энгийн хүн амтай **харгис хэрцгий** харьцсан.

Зарим улсад “харгис, хэрцгий” нэр томьёог хэрэглэж буй байдал:

1. **Харгис, хэрцгий- grausam** /Герман хэлэнд/ Гэмт хэрэгтэн хохирогчийг увайгүй, харгис хэрцгий хандлагын улмаас бие махбодын болон сэтгэцийн болон сэтгэц-биеийн тарчлаан зовоохуйц сэтгэлийн хандлага буюу ёс суртахууны хэмжүүргүй авир, гэмшилгүй, хүйтэн хөндий байдал нь айдас төрүүлхүйц байдаг гэж тодорхойлжээ.[4]

Харгислал нь бие махбодийн түвшинд бие даасан үйл явдлуудад шууд илэрч, гэмт этгээдийн хохирогчид хандах сэтгэл санааны болон сэтгэл хөдлөлийн үндсэн хандлага бөгөөд хохирогчийг бүх түвшинд, түүний сэтгэцийн болон сэтгэл хөдлөлийн хандлагаар дамжуулан гэмтээдэг.[5] ХБНГУ-ын Эрүүгийн хуульд “харгис, хэрцгий” гэсэн шинжийг хүнийг санаатай алах гэмт хэрэгт (Mord, § 211 StGB) хэрэглэдэг[6] бөгөөд хохирогчид онцгой их бие махбодын болон сэтгэлзүйн шаналал, тарчлал учруулахыг ойлгоно гэж Холбооны шүүх тайлбарласан байдаг.

Мөн харгис хэрцгий хандлага эс үйлдэхүйгээр илэрч болно. Жишээ нь зориудаар, удаан хугацаагаар өлсгөх, хоол тэжээлийн дутагдалд оруулах гэх мэт.[7]

2. Монгол хэлний их тайлбар толь бичигт **“харгис, хэрцгий”** нэр томьёог “Догшин ширүүн, харгис балмад зан авир” гэжээ.

Дээрх тодорхойлолтуудаас дүгнэхэд **“харгис хэрцгий”** гэдэг нь хүнлэг бус, энэрэх сэтгэлгүй, хатуу чанга хандлагыг илэрхийлж, энэ нь бусдыг бие-махбодь болон сэтгэлзүйн хувьд зовоон тарчлаах шинжтэй үйлдэл эс үйлдэхүйг ойлгоно.

Иймд Эрүүгийн хуулийн зарчимд **“хүнлэг бус” “хэрцгий”** гэж давхардуулсан нэр томъёог өөрчилж “хэрцгий” гэсэн үгийг хасах. Мөн зарим төрлийн хэрэгт “хэрцгий” шинжийг харгис хэрцгий эсхүл онц харгис хэрцгий гэж хүч оруулсан нь хэмжүүрийн хувьд хүний субъектив үнэлэмжээр үнэлэх нөхцлийг бий болгож байх тул энэ шинжийг нэгмөр болгон зохицуулах.

1.2 Эрүүгийн хуульд **“ноцтой”** гэдэг үг 26 удаа бичигдсэн байна. Энэ хуульд заасан "ноцтой хохирол, хор уршиг" гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно гэж тайлбарласан боловч **“ноцтой зөрчил**” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Учир нь ЭХ-ийн 6.12 дугаар зүйлд хорих ялаас хугацаанаас өмнө суллах шалгуурт ялтан **“ноцтой зөрчил**” гаргаагүй байх шалгуур орох бөгөөд ноцтой эсхүл ноцтой биш гэдэг нь хуульд заасан хэмжүүрээр биш эрх бүхий албан тушаалтны субьектив үнэлэмжээр хэмжигдэх нөхцөл бий болж байна.

Мөн “*...улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд..”* гэж тодотгон тайлбарласан нь тодорхой бус байдлыг бий болгох эрсдлийг бий болгож байна. Тухайн учруулсан хор уршиг нь ноцтой боловч халдлагад өртсөн эрх нь *ач холбогдол бүхий эрх биш* гэдгийг хэн ямар шалгуураар үнэлж, тодорхйолох нь тодорой бус байна.

Хоёр.Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг Зөрчлийн хуульд заасан зөрчлөөс ялгагадахгүй байгаа зарим тохиолдлын талаар

Эрүүгийн хуулийн Арван зургадугаар бүлэгт Хүүхдийн эсрэг 11 төрлийн гэмт хэргийг тусгасан, Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд хүүхдийн эрхийн эсрэг 15 зөрчлийг хуульчилсан боловч агуулгын хувьд давхцсан байна. Тухайлбал:

2.1 Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл, 1.1 дэх хэсэгт “хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд **гачигдуулсан”** бол зөрчилд тооцохоор хуульчилжээ. Гэтэл энэ зөрчил нь Эрүүгийн хуулийн 16.7 дугаар зүйлд заасан “Хүүхэдтэй хэрцгий

харьцах”гэмт хэргийн нэг шинж нь болохоор байна.

Учир нь:

Гачигдах-гачигдуулах гэдэг үг зүйн хувьд: Гачигдуулах гэдэг нь нэг удаагийн эсхүл түр зуур үргэлжилсэн үйлдэл эс үйлдэхүй биш бөгөөд үргэлжилсэн шинжтэй, энэ үйлдлийн улмаас хүүхэд сэтгэл санаа, бие махбодийн хувьд шаналан зовсон, хоол тэжээлийн дутагдалд орсон, сольж өмсөх хувцасгүй нөхцөл байдал үүссэн, орон байргүй буюу орогнох газаргүй, богино эсхүл урт хугацаанд амь нас, эрүүл мэнд нь эрсдэлт орсон байхыг ойлгоно.

Монгол хэлний тайлбар толь бичигт “Хүн элдэв эд хэрэглэгдэхүүнээр дутагдах, зовлон зүдгүүрт мөхөсдөн мохохыг гачигдах” гэж тайлбарлажээ.

2.2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйлд “**уламжлалт эм”-**ийг оруулаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Хүний эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан, ***хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг*** *үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсэн бол*

Нийгэмд уламжлалт аргаар бэлдсэн, хүний эрүүл мэндэд ач холбогдолтой, тодорхой төрлийн өвчнийг илааршуулах чадалтай гэж итгүүлэн мал, амьтны эсхүл ургамлын гаралтай **“тан”** гэх нэршилтэй уламжлалт эмийг ахуйн хүрээнд бэлтгэж боловсруулан, зарж борлуулж, ашиг олж байгаа үйлдэл түгээмэл байгаа нь нууц биш боловч уламжлалт эмийг зөвшөөрөлгүй *үйлдвэрлэсэн, импортолсон, худалдсан, түгээсэн* үйлдлийг хуулиар хориглоогүй зөвхөн “*эм, биобэлдмэл*” гэж хязгаарласан бөгөөд, уг үйлдлийн улмаас бусдад хор уршиг учирсан тохиолдолд ямар хуулиар хариуцлага хүлээх нь тодорхой бус байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд “эм”, “уламжлалт эм” гэдгийг хоёр салгаж тайлбарлажээ. Уламжлалт эм нь эм гэсэн ангилалдаа багтах эсэх нь Эрүүгийн хуулийн дээрх заалтад тодорхойгүй байна. Учир нь дээрх хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.1-д "эм" гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зориулалттай, хүний физиологийн үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдэл нь эм судлал, эмнэлзүйн туршилтаар нотлогдсон, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг, тодорхой хэлбэртэй **бүтээгдэхүүнийг**

4.1.6-д "уламжлалт эм" гэж уламжлалт анагаах ухааны эх сурвалжид үндэслэн байгалийн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн тодорхой тун, хэмжээ бүхий эмийг” ойлгоно гэж тодорхойлсон байна.

Хэрэв Эрүүгийн хуульд заасан “эм” гэдэгт “уламжлалт эм” багтана гэж үзвэл Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

2.3 Зөрчлийн хуулийн 6.15 дугаар зүйлийн 3.2. дахь хэсэгт *” **хүний эрүүл мэндэд хортой сав, баглаа боодол ашиглан** хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулсан, үйлчилсэн нь **эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй** бол .....торгоно*” гэсэн

зохицуулалт байх бөгөөд ямар тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Эрүүгийн хуульд дээрх зүйл заалттай холбоотой зохицуулалт байхгүй болно.

2.4. ЭХТА-ийн 20.16 дугаар зүйлд заасан Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг нь олон нийтийн аюулгүй байдлын, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг бөгөөд уг гэмт хэргийг **“бүлэглэж”** гэж хязгаарласан ба хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр хохирол учруулаагүй **“хүнд”** хохирол учруулсан нь энэ зүйл хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байна.

Гэтэл дээрх гэмт хэргийг бүлэглэж эсхүл ганцаараа үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр хохирол учруулан олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулж олон нийтийн аюулгүй байдалд халдсан тохиолдолд Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдсэнд тооцогдохоор байгаа нь хууль нэг мөр хэрэгжихэд эрсдэл бий болгож байна.

Дүгнэлт, санал.

Нэг. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж түүхэн хөгжлийн хувьд эрүүгийн хууль төрөлжүүлэх тусам түүнд хэрэглэсэн нэр томьёо нь улам боловсронгуй болох тусам үгэнд хэмнэлттэй байх зарчмыг баримталж буй нь дэвшилттэй боловч уг зүйн хувьд дахин эргэж харах шаардлага бий болж байна. Иймд Эрүүгийн хуульд хэрэглэсэн нэр томьёо, ухагдахуун, хуулийн бүтэц Хууль тогтоомжийн тухай хуулд тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх.

Хоёр. Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн орчуулга хэл зүй, найруулгын шаардлага хангаж буй эсэхийг судлан, Эрүүгийн хуульд гэмт хэрэг болгон оруулсан заалтууд хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх.

Гурав. Хөндсөн сэдэв нь зарим төрлийн хэргээр жишээ авсан тул Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль дах давхцлыг судалж, зарим төрлийн гэмт хэргийг шинээр томъёолох, үг зүйн хувьд боловсруулалт хийх шаардлагатай байна.

[1]Gemeinsame Geschäftsordnung der Bundesministerien /GGO/ Stand: 22. Januar 2020, § 42 Gesetzesvorlagen der Bundesregierung. Gesetzentwürfe müssen sprachlich richtig und möglichst für jedermann verständlich gefasst sein. Gesetzentwürfe sollen die Gleichstellung von Frauen und Männern sprachlich zum Ausdruck bringen. Gesetzentwürfe sind grundsätzlich dem Redaktionsstab Rechtssprache zur Prüfung auf ihre sprachliche Richtigkeit und Verständlichkeit zuzuleiten. Die Zuleitung soll möglichst frühzeitig erfolgen. Das Ergebnis der Prüfung hat empfehlenden Charakter.

[2]АкадемичС.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” 2011 он

[3]Хууль зүйн техник, нийтлэл, 2015 он судлаач Г.Оюунболд

[4] https://de.wiktionary.org/wiki/grausam

[5] BGHSt 45, 189 (195 f.).

[6] Mörder ist, wer

aus Mordlust, zur Befriedigung des Geschlechtstriebs, aus Habgier oder sonst aus niedrigen Beweggründen,
heimtückisch oder grausam oder mit gemeingefährlichen Mitteln oder
um eine andere Straftat zu ermöglichen oder zu verdecken,
einen Menschen tötet.

[7] BGH Beschl. v. 13.03.2007 – 5 StR 320/06.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/727